



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 04 дугаар сарын 03 өдөр Дугаар 28

Хэрлэн сум

XXVIII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 28 дугаар хуралдаан 2021 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 09:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 72,6 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөө.

СОНССОН НЬ:

1.Ерөнхий боловсролын сургуулиудын 3 дугаар улирлын хичээлийг танхимын сургалтаар үргэлжлүүлэх эсэх талаар хэлэлцэх,

Боловсрол, соёл урлагийн газар

2.Аймгийн Онцгой комиссоос томилогдсон ажлын хэсэг Булган, Матад, Халхгол сумдад ажилласан талаар мэдээлэл танилцуулах,

Аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат

3.Дулааны улирал ирж барилгын ажил эхлэх болсонтой холбогдуулан аймгийн хэмжээнд хийгдэх барилгын салбарын бүтээн байгуулалтын ажлын талаар судалгааг танилцуулах,

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар

4.“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн “Хилийн Баянхошуу боомтоор тусгай тоноглол бүхий техник, багаж хэрэгслийг нэвтрүүлэх тухай” хүсэлтийн дагуу мэргэжлийн байгууллагуудтай хамтран судалсан талаарх мэдээлэл танилцуулах,

АЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэс

5.Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 78 дугаар тогтоолоор Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал сунгасантай холбогдуулан аймгийн хэмжээнд шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүд ажиллахад шаардагдах зардлын тооцоог танилцуулах,

Эрүүл мэндийн газар

6.Эрсдэлтэй аймгуудаас уул уурхайн компаниудын ажилчдын ээлж солилтыг зөвшөөрөх эсэх талаар хэлэлцэх,

Эрүүл мэндийн газар

М.Бадамсүрэн
Д.Баттулга

7.Ресторан, баар, дэлгүүрийн ажиллах цагийн хуваарьт өөрчлөлт оруулах эсэх, шөнийн цагаар иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлаж ажиллах саналыг танилцуулах,

Цагдаагийн газар

8.Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах ажлын талаар танилцуулах,
Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар

9.Аймгийн Онцгой комисст иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн хүсэлт, албан бичиг танилцуулах.

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн А.Нансалмаа,
Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч,
Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир нарт:

1.1.Ачаа тээврийн жолооч нартай уулзалт зохион байгуулж, гэр бүлийн гишүүдээс хичээл, албан ажилтай иргэд байдаг тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар санал солилцож, аймгийн Шуурхай штабын дараагийн хуралд танилцуулах,

Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн А.Нансалмаа-д:

1.2.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал сумдын Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, аймгийн төвийн цэцэрлэгийн үйл ажиллагааг хэвийн буюу өмнөх горимоор, аймгийн төвийн Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын хичээлийг 1 болон 3 дахь 7 хоногт танхимаар, 2 болон 4 дэх 7 хоногт цахимаар, дунд, ахлах ангийн сурагчдын хичээлийг 2 болон 4 дэх 7 хоногт танхимаар, 1 болон 3 дахь 7 хоногт цахимаар эхлүүлэхийг зөвшөөрсөн аймгийн Онцгой комиссын тогтоол гаргахыг,

Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн А.Нансалмаа,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,



Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах нарт:

1.3.Аймгийн Онцгой комиссоос гарсан шийдвэрүүдийг танилцуулах, 7 хоног бүр аймгийн Онцгой комисст мэдээлэл танилцуулж байх талаар сумдын Онцгой комисстой цахим хурал зохион байгуулж үүрэг чиглэл өгөхийг,

Аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн,
Аймгийн Засаг даргын зөвлөх Х.Энх-Отгон,

Аймгийн ерөнхий тэрхвар судлаач эмч, Онцгой комиссын гишүүн Б.Ганганцэцэг нарт:

1.4.Аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргаар ахлуулсан коронавируст халдварын мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх багийг байгуулж, нарийн

 /М.Бадамсүрэн
 Д.Баттулга

бичгийн даргаар аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, бүрэлдэхүүнд Засаг даргын орон тооны зөвлөхийг ажиллуулах.

Хоёр Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн Д.Дамдинбазар-д:

2.1 Дорнод аймагт Барилга угсралт, барилгын ажил гүйцэтгэж буй аж ахуйн нэгж, байгууллагуудтай хариуцлагын гэрээ байгуулах.

2.2 Халдварын тохиолдол бүртгэгдсэн орон нутгаас барилга угсралт, барилгын ажлын чиглэлээр ажилчин, бараа материал тээвэрлэх аж ахуйн нэгж, байгууллагуудын талаар мэдээллийг урьдчилж аймгийн Шуурхай штабт танилцуулж мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах.

Гурав Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

3.1 Аймгийн Онцгой комиссын 2021 оны 20 дугаар тогтоолыг хүчингүй болгох, карго тээвэр, барилгын материал тээвэрлэлтийг зохицуулах ажлын хэсгийг нэгтгэх, ажлын хэсгүүдийн нарийн бичгийн даргаар Онцгой байдлын газрын албан хаагчийг томилж "Ачаа тээврийн үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хэсэг томилгох" аймгийн Онцгой комиссын тогтоолыг шинэчлэн гаргах.

Зрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа-д:

3.2 Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон байдлын зэрэгт шилжсэн хугацааг 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал сунгасантай холбогдуулан аймгийн Шуурхай штаб, Баянтүмэн, Хөленбуяр, Хэрлэн сумын шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүд 32 хоног ажиллахад шаардагдах шатахуун, ариутгалын бодис, хамгаалах хувцас хэрэгсэл, хоол, бичиг хэргийн нийт 29,746,642 төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг.

Дөрөв Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:



4.1 Улсын хэмжээнд коронавируст халдвар /COVID-19/ -ын тархалт эрс нэмэгдсэнтэй холбогдуулан Дорнод аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг уул уурхай олборлолт, зам барилга, дэд бүтэц, хөдөө аж ахуй, газар тариалангийн аж ахуй нэгж байгууллагуудын ажилчдын ээлж солих ажиллагааг сар бүрийн 10, 20, 30-ны өдрүүдэд халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэн зохион байгуулж ажиллах тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргах.

Тав Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

5.1 Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан халдвар хамгааллын дэглэмийг баримтлан бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах.

Зургаа Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа:

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг:

 /М.Бадамсүрэн
 Д.Баттуула

Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

6.1.Согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуй нэгж байгууллагуудтай хариуцлагын гэрээ байгуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах:

6.2.Халдварын тархалт эрс нэмэгдсэнтэй холбогдуулан согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуйн байгууллагууд халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөж ажиллах тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргах,

6.3. Халдварын тархалт эрс нэмэгдсэнтэй холбогдуулан Матад, Хөлөнбуйр, Цагаан-Овоо, Баян-Уул сумын Засаг дарга нарт хөдөлгөөнт хяналтын пост ажиллуулах тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргах,

АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д:

6.4.Зэвсэгт хүчний 327 дугаар анги, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Статистикийн хэлтэс, Татварын хэлтэс, Ус, цаг уур, орчны шинжилгээний газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хөгжимт драмын театр, Гадаадын харьяатын газар, Политехникийн коллеж, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Дорнод их сургуулийн албан хаагчдыг аймгийн Шуурхай штаб, Хөлөнбуйр сумын хяналтын цэгт томилж ажиллуулахыг зөвшөөрөв,

Долоо Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа-д:

7.1.Баянтүмэн гүүрний хяналтын цэгт ажиллахад хувийн хамгаалах хэрэгсэл худалдаж авахад шаардагдах 2,240,500 төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын зөвөлд танилцуулах,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунва-д:

7.2.Улсын Онцгой комисс даргын "Гэрээг пос машин нэвтрүүлэх тухай" албан бичгийн дагуу зардлыг тооцож аймгийн Засаг даргын зөвөлд танилцуулах,

7.3.Өрнө дорнын соёл хөгжлийн харилцааны зөвлөл байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газраас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийг аймгийн Засаг даргын зөвөлд танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

7.4.Хилийн Эрээнцав боомтод үүрэг гүйцэтгэн хяналт тавин ажиллаж буй албан хаагчдын халдвар хамгааллын хэрэгсэл болон хүнсний зардалд дэмжлэг үзүүлэх зорилгоор шатахуун импортлогч аж ахуй нэгж байгууллагуудаас Дотоодын хүмүүнлэгийн тусламжид ирүүлсэн мөнгөн тусламжийг тухай бүр холбогдох газарт шилжүүлж ажиллахыг зөвшөөрөв,


/М.Бадамсүрэн

/Д.Баттулга

АЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын
гишүүн Ц.Баяржаргал-д.

7.5. "Их монгол барилга" ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийг судалж, Улсын Онцгой комисст уламжлахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА



М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА



Д.БАТТУЛГА

